

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№21/540

ШУС, НУС

2020

**МОНГОЛЫН СЭТГҮҮЛ ЗҮЙН СУДЛАЛ, ШҮҮМЖЛЭЛД ДОКТОР,
ПРОФЕССОР Т.БААСАНСҮРЭНГИЙН ОРУУЛСАН ХУВЬ НЭМРИЙГ
ҮНЭЛЭН ЦЭГНЭХҮЙ**

(Доктор, профессор Тугалхүүгийн Баасансүрэнгийн 70 насны ойд)

М.Зулькафиль*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, шинжлэх ухааны доктор (Sc.D)

Түлхүүр үг: Тугалхүүгийн Баасансүрэн, сэтгүүл зүйн шүүмж, судалгаа, түүх

Монголын сэтгүүл зүйн судлал, шүүмжлэлийг хөгжүүлэхэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан цөөн судлаач, шүүмжлэгчийн нэг бол доктор, профессор Т.Баасансүрэн юм. Орчин үеийн Монголын сэтгүүл зүйн судлалыг судлаач, шүүмжлэгч, багш сурган хүмүүжүүлэгч Т.Баасансүрэнгийн бүтээлгүйгээр төсөөлөх боломжгүй. Т.Баасансүрэн бол сэтгүүлч, зохиолч, ОНМХ-ийн нэртэй менежер, багш сурган хүмүүжүүлэгч, сэтгүүл зүйн судлаач, шүүмжлэгч, өөрөөр хэлбэл үгийн урлаг, сэтгүүл зүйн салбарт ховор заяагдсан хосгүй авьяастан “арван хуруу нь тэгш хүн” юм. Бид энд түүний зөвхөн сэтгүүл зүйн судлал, шүүмжлэлд оруулсан хувь нэмрийн талаар товч, тоймлон ярихыг оролдъё. Товч гэхийн учир нь сэтгүүл зүйн судлалд амьдралынхаа 40 гаруй жилийг зориулж, судалгааны олон арван ном, өгүүлэл, шүүмж бичсэн түүний бүх судалгааны бүтээлийн талаар нэг өгүүллийн хэмжээнд тогтож ярих боломжгүй юм.

Доктор, профессор Т.Баасансүрэнгийн сэтгүүл зүйн судалгааг ОНМХ-ийн түүх, онол, практик, арга зүй, сэтгүүл зүйн шүүмж гэсэн таван гол чиглэлд авч үзэх боломжтой бөгөөд тэрээр аль ч чиглэлд жинтэй хувь нэмэр оруулж, сэтгүүл зүйн судлалын түүхэнд томоохон байр эзэлж, мөнхрөн үлдэх бүтээл туурвисан гэдгийг онцлон хэлэх хэрэгтэй. Харин судалгааны бүтээлүүдийг нь төрөл, хэлбэрийн хувьд нэг сэдэвт зохиол буюу монограф, тойм судалгааны ном, эрдэм шинжилгээний өгүүлэл, эрдэм шинжилгээний илтгэл, шүүмж, сурах бичиг, гарын авлага гэж ангилж болно.

Доктор Т.Баасансүрэн сэтгүүл зүйн судалгааны ажлыг одоогоос 41 жилийн өмнө буюу 1979 онд ЗХУКН-ын Төв Хорооны дэргэдэх Нийгмийн Ухааны Академийн аспирантурт элсэн суралцсан цагаасаа эхэлжээ. Залуу судлаач гурван жилийн турш тухайн үеийн сонин хэвлэлийн хамгийн чухал сэдэв болох үйлдвэрлэлийн тэргүүн туршлагыг тусгах, түгээн дэлгэрүүлэх арга барил, нийтлэлийн ур чадвар, үр нөлөөг судалж 1982 онд “БНМАУ-ын хэвлэлд үйлдвэрлэлийн тэргүүн турш-

лагыг түгээн дэлгэрүүлж байгаа нь” сэдвээр түүхийн ухааны докторын зэргийг амжилттай хамгаалжээ. 1984 онд эл бүтээлийг “Тэргүүн туршлагыг хэвлэлээр сурталчлах асуудалд” нэрээр ном болгон хэвлүүлсэн нь 1970-аад онд хэвлүүлсэн нэрт судлаач, доктор Г.Дэлэгийн “Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл” (1965), “Монголын хэвлэл” (Боть I, II. 1971, 1972) нэртэй гурван боть нэг сэдэвт бүтээлийн дараа гарсан, тогтмол хэвлэлийн онол, практикийг өндөр түвшинд хосолж чадсан судалгааны үнэ цэнтэй бүтээл байлаа. Энэ утгаар нь судлаач Т.Баасансүрэнг нэрт судлаачийн сэтгүүл зүйн судлал дахь үйл хэргийг нэр төртэй үргэлжлүүлэгч гэж хэлж болно. Тухайн үед МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимд дөнгөж ажилд орсон залуу багш надад энэхүү нэг сэдэвт бүтээл лекц, семинарын хичээлийг бэлтгэхэд онол, арга зүйн хувьд их л тус болж байсныг онцлон хэлье. Өөр нэг хэлэх зүйл бол 1980-аад оны эхэнд Москвад сэтгүүл зүйн чиглэлээр аспирантурыг төгсөж, эрдмийн зэрэг хамгаалж ирсэн арваад хүний дотроос өөрийнхөө диссертацийг ном болгон хэвлүүлж, олны хүртээл болгосон цорын ганц хүн бол Т.Баасансүрэн юм. Энэ бол зохиогчийн бүтээлч сэтгэлгээ, хөдөлмөрч чанар, сэтгүүл зүйн судлалд үнэнч байгаагийн нэг илрэл мөн юм.

Улмаар судлаач Т.Баасансүрэн Монголын сэтгүүлчдийн мэргэжлийн байгууллагын үүсэл, хөгжил, төлөвшлийн түүхэн замналыг судалж “Сэтгүүлчийн байгууллагын үүсэл хөгжлийн тухай тэмдэглэл” (1987), ОНМХ-ийн хэрэглэгчдийн дунд явуулсан анхны социологийн судалгааны дүнг нэгтгэж “Асуулга-судалгааны дүн юу харуулав?” (1987), ОНМХ-ийн янз бүрийн асуудлын хүрээнд бичигдсэн судалгааны бүтээ-

лүүдийн эмхэтгэн “Эрэл бодол эргэцүүлэл” (1989) хэмээх судалгааны бүтээлүүдийг хэвлүүлсэн байна.

Судлаач 1990-ээд оны сүүлч, 2000 оны эхээр Монголын сэтгүүл зүй судлалд бараг судлагдаагүй хоёр чухал сэдвийг барьж аваад нэлээд гүнзгийрүүлэн судалж таван чамбай бүтээл туурвисан нь судлаачдын анхаарлыг ихээр татсан билээ. Энэ бол нэг зууны турш тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж, гадаад, дотоодын уншигч, сонсогчдыг мэдээллээр хангахад чухал үүрэг гүйцэтгэж буй МОНЦАМЭ агентлагийн тухай “МонТА буюу МОНЦАМЭ: түүний өчигдөр ба өнөөдөр, маргааш” (2002), “Миний нэр, миний гэр-МОНЦАМЭ” (2002), “МОНЦАМЭ: үе үеийнхэн” (2002) хэмээх бүтээл юм. Энэ бүтээлүүд Монгол Улсын гадаад сурталчилгааны гол хэрэгсэл болсон МОНЦАМЭ агентлагийг судалгааны бие даасан сэдэв болгон сонгон авч, түүний үүсэл, хөгжил, төлөвшлийн асуудлыг улсуурьтай судалж, үнэлэлт өгөхийн зэрэгцээ түүний хөгжлийн хэтийн төлөв, чиг хандлагыг тодорхойлсноороо үнэ цэнтэй бүтээл болсон юм. Урьд өмнө зуун жилийн түүхтэй МОНЦАМЭ агентлагийн тухай товч тойм, танилцуулга төдий зүйл гарч байсан бол Баасансүрэн доктор анх удаа энэ агентлагийг нухацтай судалж шинжлэх ухааны үндэстэй үнэлэлт дүгнэлт өгч, үйл ажиллагааг нь улам боловсронгуй болгох талаар практик зөвлөмжийг санал болгосноороо чухал ач холбогдолтой болжээ.

Монголын сэтгүүл зүй судлалд маш бага судлагдсан, зайлшгүй судлах шаардлагатай өөр нэг сэдэв бол сэтгүүлчийн ур чадварын онол, практик, арга зүйн асуудлууд юм. Судлаач энэ асуудлыг тал бүрээс нь гүнзгийрүүлэн судалж “Сэтгүүлчийн уран чадварын тухай яриа” (1999),

“Сэтгүүлчийн уран чадварын асуудал: уламжлал ба шинэчлэл” (2002) гэсэн хоёр бүтээл туурвисан нь өнөөдөр ч үнэ цэнээ алдаагүй, сэтгүүлч, багш судлаачид, мэргэжлийн ангийн оюутнуудын ширээний ном болсоор байна. Энэхүү бүтээлүүд 1985 онд хэвлэгдсэн доктор Д.Нямсүрэнгийн онолын шинжтэй “Сэтгүүлчийн ур чадвар” бүтээлийг эс тооцвол онол, практикийг хосолсон, манай үе үеийн сэтгүүлчдийн нийтлэлийн бүтээлүүдийн бичлэгийн уран чадварт дүн шинжилгээ хийж, алдаа оноог нь дүгнэж цэгнэсэн, уран чадварыг сайжруулах арга замыг эрж хайсан анхны бүтээл юм. Дээрх бүтээлүүд сэтгүүлчийн уран чадварыг судлах ажлын эхлэлийг тавьсан бөгөөд дараагийн жилүүдэд доктор, профессор Л.Норовсүрэнгийн “Монголын нийтлэл” (Боть I, II, III. 2004, 2005, 2007), М.Зулькафилийн “Сэтгүүлчийн ур чадвар-I, II, III. 2009, 2012 “гурван боть сурах бичиг, судалгааны бүтээл хэвлэгдсэн байна. Үүнээс үзэхэд Т.Баасансүрэн доктор Монголын сэтгүүл зүй судлалд олон зүйлийн эхлэлийг тавьсан гэж үзэх үндэстэй юм.

Миний бие сэтгүүл зүйн нэрт судлаач, шүүмжлэгч Т.Баасансүрэнд судлаач хүнд байдаг хоёр чухал чанарыг өндөр үнэлдэг. Энэ бол ажилч хичээнгүй, өөрийнхөө авьяас чадвар, оюуны чадавхыг дээд зэргээр дайчилж чаддаг хөдөлмөрч чанар, мөн аливаа асуудалд маш нягт нямбай, хариуцлагатай ханддаг, судлаачийн ёс зүйг өндөр түвшинд баримталдаг чанар юм. Үүнийг доктор Т.Баасансүрэнгийн олон жилийн бүтээлч хөдөлмөрийн үр дүн болох “Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь” хэмээх долоон дэвтрээс бүрдсэн томоохон хэмжээний нэг сэдэвт зохиолыг уншиж танилцах явцад улам тод ажиглалаа.

Монголын томоохон телевизийн өдөр тутмын нөр их ажлыг удирдаж, уран зохиолын олон ном туурвиж, хажуугаар нь сэтгүүл зүйгээ судалж, судалгааны цуврал бүтээл, олон арван шүүмж бичнэ гэдэг бол амаргүй бөгөөд нэг хүнд ахадсан ажил гэдэг нь ойлгомжтой. Гэхдээ үүнийг Т.Баасансүрэн судлаач цаг тухайд нь амжуулж, тодорхой үр дүнд хүрч явааг энэхүү долоон боть судалгааны бүтээл гэрчилнэ.

Сэтгүүл зүй судлаач Т.Баасансүрэн Монголын чөлөөт арчилсан сэтгүүл зүйн үүсэл, хөгжил, төлөвшлийн асуудлыг манай орны сэтгүүл зүйн 100 орчим жилийн түүхэн туршлага, нийтлэлийн төрөл зүйл, ур чадварын уламжлал, шинэчлэлийг түүхчлэн үзэх, задлан шинжилж нэгтгэн дүгнэх, агуулгын дүн шинжилгээ хийх (контент-анализ), нэгжээс ерөнхий, ерөнхийгөөс нэгж руу шилжих, харьцуулан судлах зэрэг сэтгүүл зүйн судлалд түгээмэл хэрэглэдэг нийтлэг аргуудын тусламжтайгаар судалж “Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь” хэмээх томоохон хэмжээний нэг сэдэвт зохиол бичсэн нь зөвхөн сэтгүүл зүйн судлал, шүүмжлэл төдийгүй монголын сэтгүүл зүйд оруулсан үнэтэй хувь нэмэр, үнэлж баршгүй оюуны хөрөнгө оруулалт юм.

Энд онцлон тэмдэглэх нэг зүйл бол Монгол Улсад ардчилал оршин тогтнох, олон ургалч үзлийг хөгжүүлэх, хүмүүсийн үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх язгуур эрх чөлөөг хангахад амин чухал үүрэг гүйцэтгэдэг чөлөөт ардчилсан сэтгүүл зүйн хөгжил, төлөвшлийн асуудал бол гадаад, дотоодын судлаачдын анхаарлыг зүй ёсоор татаж буй, мөн түүнийг олон талаас нь цогц байдлаар судлахыг манай орны болон сэтгүүл зүйн хөгжлийн өнөөгийн нөхцөл байдал шаардаж

буй чухал сэдэв мөн. Судлаач ийм чухал сэдвийг сонгон авч оновчтой бүтэц, орон зай, цаг хугацааны дарааллыг тодорхой хэмжээгээр хадгалах замаар судлахыг зорилго болгосон нь арга зүйн хувьд зөв бөгөөд дэмжүүштэй эхлэл юм.

Энэхүү нэг сэдэвт бүтээл нь дотроо “XX зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл” (I ба II хэсэг), “1921 оны Ардын хувьсгал ба Монголын хэвлэлийн цаашдын хөгжил”, “1990 оны ардчилсан хувьсгал ба Монгол дахь чөлөөт хэвлэлийн хөгжил, түүний цаашдын төлөв”, “Монголын чөлөөт хэвлэлийн хөгжилд үндэсний сэтгүүлчдийн уран чадвар нөлөөлсөн нь”, “XXI зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл ба сэтгүүлчдийн уран чадварын зарим асуудал”, “Монголд чөлөөт хэвлэл “устах” аюул нүүрлэж байна”, “Монголын чөлөөт хэвлэл ба сэтгүүл зүйн шүүмж судлал, тулгамдсан зарим асуудал” гэсэн үндсэн долоон дэвтрээс бүрджээ.

Монгол дахь тогтмол хэвлэл, түүний дотор чөлөөт хэвлэлийн үүсэл хөгжил, төлөвлөлийн асуудлыг судлаач Монголын хэвлэлийн уламжлал ба шинэчлэлийн уялдаа холбоон дунд нь авч үзээд хөгжлийн цаашдын төлөв байдлын талаар таамаглал дэвшүүлж, түүнийг бодит баримтын үндсэн дээр баталж чадахуйц дүгнэлт хийснээрээ анхаарал татсан цоо шинэ ажил болжээ. Урьд нь манай сэтгүүл зүйн судлаачид энэ асуудлыг ямар нэг хэмжээнд хөндөж байсан боловч ийм цогц байдлаар авч үзээд тал бүрээс нь үнэлэлт дүгнэлт хийж байгаагүй юм. Судлаач Монголд анхны сонин хэвлэл үүсэхдээ харьцангуй чөлөөт байдалтайгаар гарч байсныг өөрийн судалгааны бүтээлдээ батлах

оролдлого хийсэн нь сонирхол татаж байна.

“XX зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл” тэргүүн дэвтрийн нэгдүгээр хэсэгт зохиогч Монголын хамгийн анхны чөлөөт хэвлэл “Шинэ толь хэмээх бичиг” сонин, түүний нийтлэлийн онцлогт хийсэн өөрийн ажиглалт болох судалгааны томоохон бүтээлийг оруулсан байна. Судалгааны энэхүү сонирхолтой бүтээлээ доктор Т.Баасансүрэн 2002 онд уншигчдадаа өргөн барьсан билээ. “Шинэ толь хэмээх бичиг” сониныг манай сэтгүүл зүйн нэрт судлаач доктор Г.Дэлэг “Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл” (1965), доктор Л.Норовсүрэн “Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм” (I боть, 2001) нэг сэдэвт зохиол болон доктор, профессор М.Зулькафиль “Монголын сэтгүүл зүйн хөгжлийн чиг хандлага: түүх, онол, практикийн асуудлууд”(1997) сэдэвт шинжлэх ухааны докторын диссертацид өмнө нь судалж уншигчдад хүргэж байсан боловч доктор Т.Баасансүрэн өөр өнцгөөс харж Монголын сэтгүүл зүйн судлалд шинэ үг хэлсэн нь үнэ цэнтэй болсон юм.

Зохиогч эл номдоо “Нийслэл хүрээний сонин бичиг” сонин, “Шинэ толь хэмээх бичиг” чөлөөт хэвлэлийн үзэл санааг үргэлжлүүлсэн нь” гэсэн судалгааны томоохон өгүүллээ оруулжээ. Энэ нь өмнөх судалгааных нь үргэлжлэл бөгөөд “Нийслэл хүрээний сонин бичиг” сонины нийтлэлүүдэд нэлээд нухацтай дүн шинжилгээ хийж, тус сонин нь “Шинэ толь”-ийн нийтлэлийн бодлогыг үргэлжлүүлэгч харьцангуй бие даасан чөлөөт хэвлэл байсныг бодит баримтын үндсэн дээр баталжээ.

Судлаач Монголын тогтмол хэвлэлийн эхийг тавьсан “Шинэ толь хэмээх бичиг”, “Нийслэл хүрээний сонин бичиг” сонинуудын дэвшилт ардчилсан

өв уламжлал, нийтлэлийн чөлөөт байдал тухайн үедээ бүрмөсөн арилж мартагдаагүй. Тэдний нийтлэлийн үйл ажиллагаа, сэтгүүлчдийн бичлэгийн арга хэлбэрийг дараа дараагийн зарим хэвлэл, тухайлбал 1922-1923 онд гарч байсан “Хураангуй сэтгүүл”, “Бюллетень МонТА” сониныхон ямар нэг байдлаар авч хэрэглэж байсан гэж үзсэн нь нэлээд гүнзгийрүүлж судлах шаардлагатай, анхаарал татахуйц дүгнэлт болжээ.

Судлаач Т.Баасансүрэн нь “Хураангуй сэтгүүл”, “Бюллетень МонТА” сонины хадгалагдан үлдсэн бүх дугааруудад сэтгүүл зүйн шинжлэх ухааны үүднээс гүнзгий дүн шинжлэл хийж, урьд өмнө судалгааны эргэлтэд огт ороогүй олон баримт мэдээллийг анх удаа судалгааны эргэлтэд оруулсан нь зөвхөн энэ бүтээл төдийгүй дараа дараагийн судлаачдын хувьд ч чухал ач холбогдолтой гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Урьд нь дээрх сонинуудын нийтлэлийн агуулга, хэлбэр, бичлэгийн арга барилд ийм дорвитой, нарийвчилсан судалгааг хэн ч хийж байгаагүй юм.

Сайшаан тэмдэглэвэл зохилтой өөр нэг зүйл бол доктор Т.Баасансүрэн Улсын нийтийн төв номын санд хадгалагдаж байгаа “Хураангуй сэтгүүл”, “Бюллетень МонТА” сонины бүх дугаарын нийтлэлийг монгол бичгээс болон орос хэлнээс орчин цагийн кирилл рүү хөрвүүлэх ажлыг удирдан зохион байгуулж, 2002 онд нийтлүүлснээ номынхоо хоёр дахь хэсэг болгож уншигчдад өргөн барьсан байна. Өмнөх ном өнөөдөр нэгэнт олдохоо байсан учир энэ нь сэтгүүл зүйн судлаач, ялангуяа манай их, дээд сургуулиудын сэтгүүл зүйн ангийн оюутнуудад судлагдахууны чухал хэрэглэгдэхүүн, гарын авлага болох нь дамжиггүй.

Зохиогч судалгааныхаа бүтээлийн дэд дэвтрийг “1921 оны ардын хувьсгал ба Монголын хэвлэлийн цаашдын хөгжил” нэртэйгээр бэлтгэжээ. Эл дэвтэрт “Монголын үнэн” сонины нийтлэлүүдэд нарийвчилсан дүн шинжилгээ хийж, мөн “Үнэн” сонины үүсэл хөгжлийг ч товч боловч хураангуйлан авч үзжээ. Уг шинжлэлийнхээ үндсэн дээр “Монголын үнэн”, “Үнэн” сонин нь Монголд намч, ангийн хэвлэлийн эхлэлийг тавьж, манай орны сэтгүүл зүйн хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулж, гүнзгийрүүлэн хөгжүүлсэн байна гэсэн зөв зүйтэй дүгнэлтийг хийсэн байна. Хэдийгээр энэ дүгнэлт цоо шинэ зүйл биш боловч зохиогч асуудалд арай өөр өнцгөөс нь хандаж, орчин үеийн сэтгүүл зүйн судлалын арга зүйн үүднээс хандсанаараа онцлогтой юм.

Доктор Т.Баасансүрэн тогтмол хэвлэл Монголд хэрхэн яаж бүрэлдсэн төлөвшсөн, эрх баригч намаас нийтлэлийн бодлогыг удирдан чиглүүлэх явцад нийтлэлийн үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд нөлөөлөхүйц ямархуу арга хэлбэр тогтон хэвшиж байсныг үйлдвэрлэлийн тэргүүн туршлагыг БНМАУ-ын хэвлэлээр сурталчлан дэлгэрүүлж байсан жишээ баримтаар өгүүлсэн нь мэдээллийн багтаамж, танин мэдэхүйн ач холбогдлын хувьд сонирхол татахуйц нэн шинэлэг болжээ. Учир нь шинжлэх ухааны ололт амжилт, шинэ тэргүүний дэвшилт зүйлийг амьдрал практикт нэвтрүүлэх нь аль ч нийгмийн хувьд амин чухал асуудал, тулгамдсан зорилтын нэг байдаг билээ. Нөгөө талаар орчин үеийн сэтгүүл зүйн олон түмний идэвх санаачилгыг дээшлүүлэх, сэтгэл зүйд нь нөлөөлөх, практик үйл ажиллагаанд татан оролцуулахад чиглэгдсэн үйл ажиллагаа нь аливаа шинэ сэргэг зүйлийг сурталч-

лах, түгээн дэлгэрүүлэх, оршиж буй дутагдал доголдлыг илчлэн шүүмжлэх замаар илэрдэг онцлогтой учир асуудалд ингэж хандах нь зөв юм.

Энэхүү нэг сэдэвт бүтээлийн анхаарал татахуйц нэн шинэлэг хэсэг бол “1990 оны ардчилсан хувьсгал ба Монгол дахь чөлөөт хэвлэлийн хөгжил, түүний цаашдын төлөв” хэмээх гутгаар дэвтэр мөн. Учир энэ асуудал нэг талаар судлаачаас багагүй хүч хөдөлмөр шаардахуйц нэлээд нарийн төвөгтэй, нөгөө талаар маш олон баримт мэдээлэл судалгааны эргэлтэд орж, бие даасан судлагдахуун болж хараахан чадаагүй юм. Судлаач энэ дэвтэрт “Үнэн” сонин нь ерээд оны эхээр нийгмийн өөрчлөлт шинэчлэлийг эхлүүлэхэд хэрхэн яаж нөлөөлсөн, чөлөөт ардчилсан хэвлэл Монголд жинхэнэ утгаараа хөгжин төлөвшиж байгаа, төр засгаас чөлөөт ардчилсан хэвлэлийг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх явц, тэрчлэн чөлөөт хэвлэл бизнесийн нэг хэлбэр болж хувирсан хийгээд хөгжлийнх нь цаашдын чиг хандлагын тухайн асуудлуудыг харилцан уялдаа холбоонд нь авч үзжээ.

Ерээд оны зарим гол хэвлэлүүдийн нийтлэлд ажиглалт хийж, Монголд ардчилсан хувьсгалыг ялалтад хүргэхэд чөлөөт хэвлэлийн нийтлэлийн үйл ажиллагаагаараа тусалж дэмжиж явсан гол баатруудтай хийсэн ярилцлагаараа өөрийн үнэлэлт дүгнэлтээ баталгаажуулсан нь бүтээлийн үнэ цэнэ, үр өгөөжийг дээшлүүлэхэд нөлөөлөхүйц зөв зүйтэй алхам болсон байна.

Сүүлийн гучаад жилд Монголд хөгжсөн ардчилсан чөлөөт хэвлэлийн талаар манай сэтгүүл зүйн цөөнгүй судлаач урьд нь өөрсдийн үгийг хэлж зохих дүгнэлт хийсэн бөгөөд доктор Т.Баасансүрэнгийн энэ бүтээл түүнд өөрийн гэсэн өнгө аястай шинэ

түрлэг нэмж, утга санааг улам гүнзгийрүүлэн баяжуулж байгаагаараа чухал ач холбогдолтой юм.

“Монголын чөлөөт хэвлэлийн хөгжилд үндэсний сэтгүүлчдийн уран чадвар нөлөөлсөн нь” хэмээх дөрөвдүгээр дэвтэртээ зохиогч манай сэтгүүл зүйн салбарт авьяас билэг, уран чадвараараа гайхагдсан нэр бүхий дөчөөд сэтгүүлчдийн уран бүтээлийг тусгайлан үзэж задлан шинжилж, тус бүрийн уран чадварын онцлогийг гаргасан нь сэтгүүл зүй судлаачид, сэтгүүлч уран бүтээлчид, мэргэжлийн ангийн оюутнуудад нэн чухал эх хэрэглэгдэхүүн болсон байна.

Ж.Цэвээн, Д.Бодоо, Ц.Нацагдорж, С.Буяннэмэх, Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, Ч.Лодойдамба, Д.Цэвэгмид, С.Дашдондов, М.Бизъяа, Өвгөөдэй Дамдинсүрэн, Л.Түдэв, С.Эрдэнэ, Д.Намдаг, Жа.Пүрэв, Г.Дамба, Х.Цэвлээ, Ш.Цэрэнпил, С.Жамбалдорж, Д.Нямаа, Ц.Дашдондов зэрэг үе үеийн сэтгүүлчдийн нийтлэлд сэтгүүл зүйн үүднээс задлан шинжлэл хийжээ. Энэ бол онцгой чухал хөдөлмөр гэж зориуд цохон тэмдэглэж хэлэхийг хүсэж байна. Учир нь Монголын сэтгүүл зүйд судлал нь боломжийн түвшинд хөгжиж байгаа боловч шүүмж нь үгүйлэгдсээр ирсэн юм. Олон арван жилийн турш ийм байдалтай байсан тэр хоосон орон зайг доктор Т.Баасансүрэнгийн шүүмж, шүүмжлэлийн бүтээлүүд бөглөж эзэнтэй болгосон гэж бүрэн үндэстэй хэлж болно. Харин сэтгүүл зүйн шүүмжийг хөгжүүлэхэд бусад эрдэмтэн судлаачид ч Т.Баасансүрэн шиг идэвх санаачилгатай хандаасай гэдгийг энэ дашрамд онцлон хэлэх байна.

Судлаач Т.Баасансүрэнгийн бичиж сүүлийн жилүүдэд төвийн хэвлэлүүдэд нийтлүүлсэн “Баримтаас дүр бүтээх ёсон” (Ш.Цэрэнпилийн “Хэнээт”

хөргийн тухай), “Удтал хүлээсэн бороо орлоо” (Ж.Мягмарсүрэнгийн “Долоо дахь гавар буюу амьтдын тухай өгүүлэгүүд” номын тухай), “Сэтгүүл зүйг баяжуулав. Хойч үе үнэлнэ” (Ц.Балдоржийн нийтлэлийн тухай), “Чөлөөт ардчилсан хэвлэлийн загалмайлан эцэг” (Ц.Дашдондовын уран бүтээлийн тухай), “Ганчимэг гайхшируулж, бас бахархал төрүүлж байна” (Б.Ганчимэгийн их аварга Д.Дагвадоржтой хийсэн ярилцлагын тухай), “Сэтгүүлчийн ширээний ном бичсэн хүний тухай өгүүлэх нь” (Х.Цэвлээгийн “Миний сэтгүүл зүй” номын тухай), “Их ба бага газрын чулууны тухай бодол, эргэцүүлэл” (Уран нийтлэлч До.Цэнджав, Б.Золбаярын номуудын тухай), “Хос мэргэжил эзэмшихийн хосгүй давуу тал” (сэтгүүлч Ш.Цэен-Ойдов, Ц.Мухар нарын нийтлэлийн тухай) зэрэг сэтгүүл зүйн шүүмжүүд нь уншигч олон түмний зүгээс болон сэтгүүл зүйн мэргэжлийн эрдэмтдээс өндөр үнэлэлт авсан билээ. Тэр бүгдийгээ нэгтгэж, шинэ бүтээлээр баяжуулаад тусгайлан ботилсон нь нийт сэтгүүлчид, ялангуяа өсөж яваа залуу нийтлэлчдэд арга зүйн чухал ач холбогдолтой юм. Тэрчлэн Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвших урт хугацааны үйл явцад үндэсний үе үеийн сэтгүүлчдийн уран чадвар шийдвэрлэх нөлөө үзүүлж байжээ гэсэн үнэлэлт дүгнэлт хийснийг хүлээн зөвшөөрөх ёстой.

Тус нэг сэдэвт бүтээлийн “XXI зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл ба сэтгүүлчдийн уран чадварын зарим асуудал” хэмээх тавдугаар дэвтэр нь дөрөвдүгээр дэвтрийн шууд үргэлжлэл юм. Учир нь “XXI зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэлийн өмнөх тулгамдсан зарим асуудал”, “МОНЦАМЭ-гийн хэвлэлүүдийн уламжлал ба шинэчлэл, тулгамдсан зарим

асуудал”, “МОНЦАМЭ агентлаг: үүсэл хөгжил, түүхэн замнал, ойрын ирээдүйн стратегийн зорилт” зэрэг онолын өгүүлэл, эрдэм шинжилгээний илтгэлийг эс тооцвол зохиолч, сэтгүүлч Б.Ганбат, С.Зэвсэг, П.Сандуйжав, Д.Хатанбаатар, Б.Монголхүү, Х.Наранжаргал, Ж.Саруулбуян, А.Даваасамбуу, Б.Элбэгзаяа, Г.Баатарнум, Р.Чулуун, Л.Гүнсэн, Г.Жанчив, Т.Ганди, До.Чулуунбаатар, Р.Эмүүжин, Д.Оюун-Эрдэнэ, сэтгүүлч-судлаач Г.Гонгоржав, төр нийгмийн зүтгэлтэн Д.Цахилгаан зэрэг уран бүтээлчдийн ном зохиол, нийтлэл, судалгааны бүтээлүүдийн талаар сэтгүүл зүйн доктор, авьяаслаг судлаач Ч.Чойсамбын үгээр хэлбэл “голыг нь онож хэлсэн, цөмийг нь базаж гаргасан, ухааж төнхсөн, учирлаж тайлбарласан, ухаарал өгсөн”¹ олон шилдэг шүүмжийг багтаажээ. Товчоор хэлбэл энэ бүтээлээрээ судлаач Т.Баасансүрэн сэтгүүл зүйн шүүмж, шүүмжлэлийг урагшаа нэгэн шат ахиулж, түүний хөгжилд томоохон хувь нэмэр оруулжээ. Шүүмж бол тухайн бүтээлийн алдаа оноог дэнсэлж, түүний учир шалтгааныг тайлбарлахын зэрэгцээ түүнийг олон түмэнд сурталчлах, тайлбарлан таниулах чухал ач холбогдолтой бичлэгийн зүйл юм. Энэ утгаараа Т.Баасансүрэн доктор олон арван шүүмжээрээ уран бүтээлчдийг олон түмэнд сурталчлах, таниулахад чухал үүрэг гүйцэтгэж яваа нэг ёсны соён гэгээрүүлэгч гэж хэлэхэд хэтрүүлэг болохгүй. Үүнийг надаас эхлээд бүтээлээ шүүмжлүүлсэн олон хүн хүлээн зөвшөөрнө гэдэгт эргэлзэхгүй байна.

“Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь” нэг сэдэвт бүтээлийн зургаадугаар дэвтэр нь “Монголд чөлөөт хэвлэл “устах” аюул нүүрлэж байна” гэсэн содон нэртэй бөгөөд

зохиогчийн хэлэх гэсэн үндсэн санааг номын нэрээс нь мэдэж болно. Энэхүү бүтээл нь “Монголын чөлөөт хэвлэлийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага”, “Өнгөрсөн түүх рүүгээ өнгийн харж өв сургамж авахын ач холбогдол ба өнөөгийн зарим сэтгүүлчийн бүтээлийн талаар товчхон өгүүлэхүй”, “Нэгэн телевизийн нэвтрүүлэг, хөтөлбөрт хийсэн зарим ажиглалт судалгаа буюу TV-9 телевизийн тухай тэмдэглэлүүд” гэсэн үндсэн гурван бүлэгтэй юм. Нэгдүгээр бүлэгт нэгэн зууны түүхтэй монголын хэвлэлийн хөгжилд XXI зууны эхний 15 жилд тохиолдож буй бэрхшээл сорилтууд, түүнийг хэрхэн яаж даван туулж буйг гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэлүүд, эрдэм шинжилгээний өгүүлүүдэд тусгасан санаа бодол, үнэлэлт дүгнэлт, практик зөвлөмж, жишээ баримтад тулгуурлан гаргажээ. Энэ бүлэгт орсон бүх 14 илтгэл, өгүүллийн гол санаа нь чөлөөт хэвлэлийн хөгжилд учирч буй саад бэрхшээл, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, шалтгаан, хөгжлийн цаашдын чиг хандлага, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх арга зам, боломж зэрэг асуудлуудад төвлөрсөн байна. Судлаач чөлөөт хэвлэл жам ёсоороо хөгжихгүй байгаа олон шалтгаан, хүчин зүйлийг нэрлэсний дотор “Монголын нийт хүн амын дөнгөж хоёрхон хувийг эзэлж байгаа олигархижсан баячууд, тэрчлэн төрөөс төрсөн тэрбумтан улстөрчид сүүлийн үед ХМХ-үүдийг өөрсдийн мэдэлд төвлөрүүлж, сэтгүүлчдийг халааслах үйл явц эрчимтэй өрнөж байна. Энэ бол монголын чөлөөт хэвлэлийн хөгжилд тохиолдож байгаа хамгийн том бэрхшээл юм. Хүн амын дөч гаруй хувь, түүний дотор сэтгүүлчдийн ихэнх нь ядуу зүдүү, цалин хөлс багатай “өлөн зэлмэн” аж төрж байгааг тэд овжноор ашиглаж

өөрсдийн дуулгавартай зарц болгон хувиргаж байна. Энэ нь Монголд захиалгат нийтлэл, нэвтрүүлэг ихсэж буйн гол учир шалтгаан юм”² гэсэн гашуун боловч үнэн бодит дүгнэлт хийсэнтэй санал нэг байна. Ийм нүдээ олсон оновчтой бөгөөд үндэслэлтэй дүгнэлт олон байгаа нь бүтээлийг сонирхолтой, үнэ цэнтэй болгоход нөлөөлжээ.

Зургаадугаар дэвтрийн хоёрдугаар бүлэгт “Монголын нууц товчоо” нийтлэлийн бүтээл болохыг түүний бичлэгийн арга хэлбэрээр баталгаажуулахыг зорилго болгосон шинэ өгүүлэл болон монголын сэтгүүл зүйг үндэслэгчдийн талаарх санаа бодлоо тусгасан өгүүлүүд, мөн зарим зохиолч, сэтгүүлчийн бүтээл, нийтлэлийн талаарх шүүмжийг багтаасан нь нэг талаар шинэлэг зүйлээр баялаг, танин мэдэхүйн чухал ач холбогдолтой, нөгөө талаар маргаан мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлэх, бусдад тухайн сэдвийн хүрээнд өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх боломж олгож байгаагаараа онцлог юм. Номын гуравдугаар бүлэгт орсон Монголын тэргүүлэх таван телевизийн нэг ТВ-9 телевизийн нэвтрүүлэг, хөтөлбөрийн талаар хийсэн судалгаа, ажиглалт тэмдэглэл нь теле сэтгүүл зүйн чиглэлээр судалгаа хийдэг хүмүүст болон телевизийн сэтгүүлчдэд хэрэгтэй эх сурвалж, чухал баримт мэдээлэл, санаа авууштай үнэлэлт дүгнэлт, практик зөвлөмж агуулжээ. Ийм бүтээл цаг үе өнгөрөх тусам түүхийн чухал эх сурвалж болон үлддэг онцлогтой. Чухам үүнд энэ бүлгийн ач холбогдол оршино.

“Монголын сэтгүүл зүйн шүүмж судлал: Сэтгүүл зүйн судлаач, шүүмжлэгч Тугалхүүгийн Баасансүрэн” номыг зохиогчид доктор, профессор Л.Норовсүрэн, судлаач Б.Уянга нарын “Доктор

Т.Баасансүрэн нь монголын сэтгүүл зүйн нэртэй судлаач төдийгүй үе үеийн олон арван сэтгүүлчийн нийтлэлүүд, ном зохиолд мэргэжлийн өндөр түвшинд шүүмж, шүүмжлэл бичсэн сэтгүүл зүйн шүүмжлэгч юм. Түүний “Монголын чөлөөт хэвлэлийн хөгжилд үндэсний сэтгүүлчдийн уран чадвар нөлөөлсөн нь”, “XXI зууны эхэн үеийн монголын чөлөөт хэвлэл ба сэтгүүлчдийн уран чадварын зарим асуудал” ботиудад орсон шүүмжлэлт өгүүллүүд нь Монголын сэтгүүл зүйн шүүмж, шүүмжлэлийг хөгжүүлэх, ялангуяа сэтгүүл зүйн шүүмж, шүүмжлэлийн зогсонги байдлыг эвдэж хөгжил хөдөлгөөнд оруулахад хүчтэй нөлөө үзүүлсэн гэж үнэлж болохоор байна”³ гэсэн дүгнэлттэй санал нэг байгаа бөгөөд үүнд орчин үеийн монголын сэтгүүл зүйн шүүмж, шүүмжлэлийг Т.Баасансүрэн судлаачгүйгээр төсөөлөх боломжгүй гэдгийг нэмэх нь зүйд нийцнэ.

Мэргэжлийн сэтгүүлч, сэтгүүл зүйн судлаач доктор Т.Баасансүрэнгийн “Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь” хэмээх долоон ботиос бүрдсэн нэгэн сэдэвт бүтээл нь Монголын сэтгүүл зүйн судлал шүүмжлэлийг хөгжүүлэхэд өөрийн жинтэй хувь нэмрийг оруулсан өгөөж сайтай, сонирхолтой, нэн шинэлэг бүтээл болсон гэдгийг онцлон тэмдэглэж байна.

Доктор Т.Баасансүрэнгийн сүүлийн жилүүдэд бичсэн судалгааны бүтээлүүдийн дотор “Монголын нууц товчоо”- нийтлэлийн дурсгалт бичиг мөн” (2014), “Сономбалжирын Буяаннэмэхийн уран бүтээл, бичлэгийн арга барил, сэтгэлгээний онцлогт хийсэн ажиглалт шинжилгээ” (2020) хэмээх томоохон хэмжээний хоёр нэг сэдэвт бүтээл гол байр эзэлдэг. Судлаач анх удаа “Монголын нууц товчоо”-г нийтлэл

зүйн онол, арга зүйн үүднээс гүнзгийрүүлэн судалж, хөдөлшгүй жишээ баримт, түүхэн эх сурвалжуудад тулгуурлан энэхүү алдарт бүтээл зөвхөн утга зохиол, түүх, хэл бичиг судлалын төдийгүй нийтлэлийн дурсгалт бичиг мөн гэдгийг баталж чадсан нь сэтгүүл зүй судлал дахь цоо шинэ үзэгдэл, нэн шинэлэг хандлага мөн. Энэ сэдвийн хүрээнд доктор Л.Норовсүрэн, До.Цэнджав, ахмад сэтгүүлч Х.Цэвлээ нар эрдэм шинжилгээний өгүүллийн хэмжээнд судалж санал дүгнэлтээ хэлж байсан бол профессор Т.Баасансүрэн энэ сэдэвт олон талаас нь иж бүрэн хандаж, улам нарийвчлан судалж, томоохон нэг сэдэвт бүтээл туурвисан нь “Монголын нууц товчоо”-г сэтгүүл зүй, нийтлэл зүйн үүднээс судлах ажлын эхлэлийг тавьж, сэтгүүл зүйн бусад судлаачдад энэ сэдвийг гүнзгийрүүлэн судлах үүд хаалгыг нээж өгсөн юм. Үүний тод жишээ бол түүний шавь М.Наранчимэг өнгөрсөн жил энэ сэдвээр сэтгүүл зүйн докторын зэргийг амжилттай хамгаалж, эрдмийн зэрэг хамгаалсан бүтээлээ бие даасан ном болгон хэвлүүлсэн явдал юм. Энэ бүхнийг үндэслэн судлаач Т.Баасансүрэн “Монголын нууц товчоо”-г нийтлэл зүйн үүднээс судлах дэг сургуулийн (школ) эх суурийг тавьсан гэж хэлж болно. Учир нь түүний шавь нар ирээдүйд энэ сэдвийн хүрээнд судалгааны цөөнгүй бүтээл өргөн барих нь дамжиггүй юм.

Өөр нэг шинэлэг бөгөөд мэдээллийн багтаамж сайтай, танин мэдэхүйн ач холбогдол өндөр, урьд өмнө судалгааны эргэлтэд ороогүй олон баримт мэдээллийг анх удаа бүтээлчээр ашиглаж, үнэ цэнтэй үнэлэлт дүгнэлт хийсэн бүтээл бол “Сономбалжирын Буяаннэмэхийн уран бүтээл, бичлэгийн арга барил, сэтгэлгээний

онцлогт хийсэн ажиглалт шинжилгээ” хэмээх нэг сэдэвт зохиол юм. Урьд өмнө С.Буяннэмэхийг гол төлөв зохиолчийн хувьд судалж, түүний үргэлжилсэн үгийн зохиол, жүжиг, яруу найрагт дүн шинжилгээ хийж байсан бол Т.Баасансүрэн түүний сэтгүүлчийн үйл ажиллагаа, нийтлэлүүдийг нарийвчлан судалж, доктор

Г.Дэлэг,

Л.Норовсүрэн нарын судалгааг шинэ санаа, баримт мэдээлэл, үнэлэлт дүгнэлтээр баяжуулж өгүүлэл, номын хэсэг, бүлгийн хэмжээнд биш бие даасан нэг сэдэвт бүтээлийн хэмжээнд өргөн тавьсан нь Монголын сэтгүүл зүй, утга зохиол судлалд оруулсан томоохон хувь нэмэр мөн. Бүтээлийн

С.Буяннэмэхийн “Монголын үнэн” сонин, Өвөр Монгол, Улаан-Үүд дэх сэтгүүлчийн үйл ажиллагаатай холбоотой сонирхолтой баримт мэдээлэл агуулсан бүлэг нь түүний намтар судлалд шинэ хуудсыг нээж, Монголын сэтгүүл зүйд эзлэх байр суурь, оруулсан хувь нэмэр, гүйцэтгэсэн гавьяат үйлсийг тод томруун харуулснаараа томоохон ач холбогдолтой, үнэ цэнтэй бүтээл болжээ. Түүнчлэн С.Буяннэмэх монголын сэтгүүл зүйд найруулал, сурвалжилсан тэмдэглэл зэрэг бичлэгийн зүйлүүдийн эхлэлийг тавьж, уран зохиолын онол, шүүмж судлалд

анхдагч гэдгийг жишээ барим-таар баталж чадсан нь зөвхөн Буяннэмэх судлалд төдийгүй сэтгүүл зүйн судлалд нэн шинэ зүйл гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

Баасансүрэн судлаач гярхай ажиглагч, онолыг практиктай оновчтой хосолж, түүнийг ул суурьтай, үнэмшилтэй тайлбарлаж,

хэр баргийн хүн анзаарахгүй өнгөрдөг жижиг зүйлийг (деталь) хүртэл олж, мэдэрч, түүнийг өөрийн болгож чаддаг цөөн судлаачийн нэг. Энэ бол туршлагатай, ясны судлаач хүнд байдаг нэн ховор чанар. Үүнийг бидний дээр дурдсан 7 боть, “Монголын нууц товчоо”, С.Буяннэмэхийн болон сэтгүүлчийн уран чадварын тухай хоёр номын аль ч нүүрнээс амархан ажиглаж болно. Судлаачийн энэ чанарыг ажигласан сэтгүүл зүйн доктор Б.Болд-Эрдэнэ: “Миний бие сүүлийн арваад жилд сэтгүүл зүйн онол, судалгааны бас чиг чамгүй олон ном бичиг унш-

сан ч ийм мэргэжлийн сайн тайлбар, гярхай ажиглалт, жишээ сонголт бүхий нь цөөн санагдана. Мөн онол судалгааг ийнхүү эх орон, ард түмнийхээ түүх, ухаанаар бахархан монгол хэмээх энгүүн уужим холч хараа, сэтгэлээр харсан нь ховор билээ”⁴ гэж тун онож хэлжээ.

«

Т.Баасансүрэн Монголын сэтгүүл зүйн эх суурийг тавьсан “Шинэ толь хэмээх бичиг” сониноос эхлээд ардчилсан чөлөөт сэтгүүл зүйн үндэс суурь тавигдах үеийн ХМХ-үүд хүртэлх үеийн сэтгүүл зүйн түүхэнд томоохон байр эзэлдэг үйл явдал, сонин хэвлэлд зөвхөн түүхэн талаас нь төдийгүй онол, практикийн үүднээс ул суурьтай үнэлэлт өгч, дүгнэлт хийж, урьд өмнө судалгааны эргэлтэд ороогүй олон баримт мэдээллийг анх удаа судалгааны эх сурвалж болгож чадсан “Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь” цуврал 7 ботиороо Монголын сэтгүүл зүй судлалд томоохон хувь нэмэр оруулсан эрдэмтэн судлаач

»

Доктор, профессор Т.Баасансүрэнгийн талаарх дээр дурдсаныг нэгтгэн дүгнэвэл:

1. Судалгааны хэд хэдэн чиглэлийн эхлэлийг тавьж, олон сэдвийг анхлан судалж, дараа дараагийн судлаачдад гүнзгийрүүлэн судлах үүд хаалгыг нь нээж өгсөн цөөн судлаачдын нэг бөгөөд ялангуяа “Монголын нууц товчоо”-г нийтлэл зүйн үүднээс судлахад томоохон хувь нэмэр оруулсан гавьяатай эрдэмтэн.
2. ОНМХ-ийн түүх, онол, практик, арга зүй, шүүмж зэрэг сэтгүүл зүйн бүх чиглэлд ижил түвшинд судалгаа хийж, судалгааны нэг сэдэвт зохиол, тойм судалгаа, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, сурах бичиг, гарын авлага зэрэг судалгааны бараг бүх төрөл, хэлбэрээр бүтээлээ туурвидаг универсал судлаач.
3. Монголын сэтгүүл зүйн эх суурийг тавьсан “Шинэ толь хэмээх бичиг” сониноос эхлээд ардчилсан чөлөөт сэтгүүл зүйн үндэс суурь тавигдах үеийн ХМХ-үүд хүртэлх үеийн сэтгүүл зүйн түүхэнд томоохон байр эзэлдэг үйл явдал, сонин хэвлэлд зөвхөн түүхэн талаас нь төдийгүй онол, практикийн үүднээс ул суурьтай үнэлэлт өгч, дүгнэлт хийж, урьд өмнө судалгааны эргэлтэд ороогүй олон баримт мэдээллийг анх удаа судалгааны эх сурвалж болгож чадсан “Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь” цуврал 7 ботиороо Монголын сэтгүүл зүй судлалд томоохон хувь нэмэр оруулсан эрдэмтэн судлаач.
4. 1930-аад оны үед Ч.Дашням, С.Буяннэмэх нар эхлэлийг тавьсан сэтгүүл зүйн шүүмжийг шинэ шатанд гаргахад үнэтэй хувь нэмэр оруулж, “Монголын чөлөөт хэвлэлийн хөгжилд үндэсний сэтгүүлчдийн уран

чадвар нөлөөлсөн нь”, “XXI зууны эхэн үеийн монголын чөлөөт хэвлэл ба сэтгүүлчдийн уран чадварын зарим асуудал” судалгааны номоос гадна сэтгүүл зүй, уран зохиол, сэтгүүл зүйн судалгааны бүтээлийн олон арван шүүмж бичсэн цорын ганц судлаач мөн.

5. Доктор Т.Баасансүрэн сэтгүүл зүйн нэрт судлаач, шүүмжлэгч, сэтгүүлч, зохиолч төдийгүй МОНЦАМЭ агентлаг, “Сэтгүүлч” сэтгүүл, ТВ-9 телевиз зэрэг хэвлэл мэдээллийн томоохон байгууллагуудыг удирдаж байсан, удирдаж буй ОНМХ-ийн шилдэг менежер мөн.
6. Судлаач Т.Баасансүрэн олон жил сэтгүүлч бэлтгэдэг их, дээд сургуулиудад цагийн болон орон тооны багшаар ажиллаж, сүүлийн арваад жил “Улаанбаатар Эрдэм” ИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийг тэргүүлж, олон арван сэтгүүлч боловсон хүчин бэлтгэх болон сэтгүүл зүйн магистрант, докторантуудын эрдмийн ажлыг удирдан хамгаалуулахад үнэтэй хувь нэмэр оруулж буй багш сурган хүмүүжүүлэгч юм.

Эшлэл

- 1 Чойсамба Ч. Доктор Т.Баасансүрэнгийн “Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь” бүтээлийн тухайд // “XXI зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл ба сэтгүүлчдийн уран чадварын зарим асуудал. УБ., 2010. х.401.
- 2 Баасансүрэн Т. Монголд чөлөөт хэвлэл “устах” аюул нүүрлэж байна. УБ., 2016. х.16.
- 3 Норовсүрэн Л., Уянга Б. Монголын сэтгүүл зүйн шүүмж судлал: Сэтгүүл зүйн судлаач, шүүмжлэгч Тугалхүүгийн Баасансүрэн. УБ., 2013. х.194.
- 4 Болд-Эрдэнэ Б. Таван ботийн тухай чадан ядан өгүүлэхүй // Т.Баасансүрэн. XXI зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл

ба сэтгүүлчдийн уран чадварын зарим асуудал. Тавдугаар дэвтэр. УБ., 2010. х.394.

хэвлэл ба сэтгүүлчдийн уран чадварын зарим асуудал. Тавдугаар дэвтэр. УБ., 2010.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Чойсамба Ч. Доктор Т.Баасансүрэнгийн “Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь” бүтээлийн тухайд // “XXI зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл ба сэтгүүлчдийн уран чадварын зарим асуудал. УБ. 2010.
2. Баасансүрэн Т. Монголд чөлөөт хэвлэл “устах” аюул нүүрлэж байна. УБ. 2016.
3. Норовсүрэн Л., Уянга Б. Монголын сэтгүүл зүйн шүүмж судлал: Сэтгүүл зүйн судлаач, шүүмжлэгч Тугалхүүгийн Баасансүрэн. УБ. 2013.
4. Болд-Эрдэнэ Б. Таван ботийн тухай чадан ядан өгүүлэхүй // Т.Баасансүрэн. XXI зуу-ны эхэн үеийн Монголын чөлөөт

Резюме

В данной статье автор анализирует основные научные труды доктора исторических наук, профессора, исследователя монгольской журналистики Т.Баасансүрена, посвященные историческим, теоретическим и практическим вопросам СМИ Монголии. На основе всестороннего анализа и исторического обзора показывает ее вклад, внесенный в исследование журналистики страны.